| 210105 | Гэрээт ажлын хөлс | 61,584,000.00 | 60,917,154.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **179,769,900.00** | **172,868,149.93** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 126,504,700.00 | 120,635,689.26 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 13,316,400.00 | 13,573,307.95 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,652,900.00 | 10,665,116.23 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,663,400.00 | 2,603,277.12 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 26,632,500.00 | 25,390,759.37 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **301,534,500.00** | **272,728,968.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 19,779,400.00 | 10,051,637.37 |
| 210302 | Түлш, халаалт | 274,495,400.00 | 258,878,881.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,400,000.00 | 1,720,530.00 |
| 210304 | Байрны түрээс | 2,859,700.00 | 2,077,920.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **82,884,700.00** | **82,435,632.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,615,000.00 | 5,948,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 38,582,600.00 | 38,817,980.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,532,400.00 | 4,612,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,750,000.00 | 1,303,900.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 6,341,900.00 | 5,478,102.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 25,062,800.00 | 26,274,250.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **79,544,900.00** | **68,087,050.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 29,927,600.00 | 29,927,600.00 |
| 210502 | Хоол, хүнс | 41,972,000.00 | 30,528,450.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 7,645,300.00 | 7,631,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **31,798,800.00** | **31,729,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 19,603,800.00 | 19,579,800.00 |
| 210602 | Тавилга | 0.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,083,300.00 | 2,059,300.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 10,111,700.00 | 10,090,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **9,882,400.00** | **7,166,500.00** |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,882,400.00 | 7,166,500.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,322,900.00** | **6,507,873.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,043,400.00 | 1,994,200.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,994,400.00 | 1,735,200.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 574,000.00 | 308,740.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 405,000.00 | 245,213.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 275,000.00 | 132,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,632,100.00 | 1,718,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 399,000.00 | 374,020.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **30,813,100.00** | **29,199,968.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,114,100.00 | 22,917,968.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,699,000.00 | 6,282,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **63,325,000.00** | **60,062,300.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **63,325,000.00** | **60,062,300.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 21,036,400.00 | 18,085,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 38,914,000.00 | 38,914,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,374,600.00 | 3,062,400.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **81,286,900.00** | **70,720,124.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 81,286,900.00 | 70,720,124.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **59,723,000.00** | **30,000,000.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 59,723,000.00 | 30,000,000.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,261,514,200.00** | **2,207,051,772.10** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,304,612,000.00** | **1,275,613,646.03** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.00 | 0.00 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,233,325,100.00 | 1,204,326,782.03 |
| 310004 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 71,286,900.00 | 71,286,864.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **855,884,400.00** | **806,074,102.07** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 855,884,400.00 | 806,074,102.07 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **22,017,800.00** | **21,440,100.00** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,017,800.00 | 21,440,100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **79,000,000.00** | **103,923,924.00** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 43,200,000.00 | 103,923,924.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 35,800,000.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 50,566,780.80 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 111,507,708.40 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **571.00** | **571.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **7.00** | **7.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 7.00 | 7.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **114.00** | **114.00** |
| 620001 | Удирдах ажилтан | 12.00 | 12.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 66.00 | 66.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 25.00 | 25.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 11.00 | 11.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **336.00** | **336.00** |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **242.00** | **242.00** |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 242.00 | 242.00 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | **94.00** | **94.00** |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 94.00 | 94.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **114.00** | **114.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 10.00 | 10.00 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 36.00 | 36.00 |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 4.00 | 4.00 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 17.00 | 17.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 34.00 | 34.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 7.00 | 7.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | 6.00 | 6.00 |

20 УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.6. АУДИТ ХИЙСЭН НЭГТГЭСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**/төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **250,927,285.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **250,927,285.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **213,165,985.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **68,679,100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 62,974,300.00 |
| 210104 | Урамшуулал | 5,704,800.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,774,550.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,774,550.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,430,838.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 456,438.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 263,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,211,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **86,711,644.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 83,367,294.00 |
| 210502 | Хоол, хүнс | 3,344,350.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **32,201,406.00** |
| 210602 | Тавилга | 1,600,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 30,201,406.00 |
| 210604 | Урсгал засвар | 400,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,304,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 280,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,024,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **14,064,447.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,102,447.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,962,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,761,300.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **30,690,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 30,690,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **7,071,300.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 7,071,300.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **250,927,285.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **250,927,285.00** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 11,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,250,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 228,677,285.00 |

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Түргэн сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Р.Аюуш гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Түргэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Шалгагдагч этгээд, түүний орчин ба дотоод хяналт

Түргэн сумын Засаг дарга нь "Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид түшиглэсэн үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтэц, аялал жуулчлал хөгжсөн, уламжлалт болон эрчимжсэн мал аж ахуй, газар тариалан бүхий, хүний хөгжлийг дээдэлсэн, чинээлэг иргэдтэй сум болно" гэсэн гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Хөдөө аж ахуйн салбарыг эрчимжүүлэн хөгжүүлэх
- Байгаль хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх
- Орон нутагт дэд бүтэц, бизнесийн орчныг сайжруулах
- Байгалийн баялаг, орон нутгийн нөөц боломжид тулгуурлан жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх
- Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаан чанар хүртээмжийг дээшлүүлэх
- Төр хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Малын тоо толгойн албан татварын тухай хууль
- Нийгмийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2021 оны төсвийн тухай хууль
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор "төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 20 ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

Шалгагдагч этгээдийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын санхүүгийн нэгтгэсэн тайланд мөрдөх тусгайлан баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй бөгөөд Сангийн яамнаас гаргасан бодлого шийдвэрүүдийг хэрэгжүүлэн и-баланс цахим программ хангамж ашиглан холбогдох хууль тогтоомж, Нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан ашиглаж байна.

Түргэн сумын Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түргэн сумын Засаг даргын 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 35.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөхгүйгээр нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,590.9 сая төгрөгийн 1 хувь буюу 35.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 28.7 сая төгрөгөөр тогтоолоо. Материаллаг байдлыг шинж чанарын хувьд авч үзээгүй болно.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Түргэн сумын Засаг даргын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,771.9 сая төгрөгөөр буюу 23.5 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал , үндсэн хөрөнгийн данс байна.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төгрөг/

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 144.0 | 290.7 | 146.7 |
| Авлага | 178.1 | 266.9 | 88.7 |
| Урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 293.6 | 312.3 | 18.7 |
| Үндсэн хөрөнгө | 6,895.7 | 8413.5 | 1517.8 |
| **Нийт хөрөнгийн дүн** | **7,511.5** | **9283.4** | **1771.9** |
| Нийт өр төлбөр | 3.0 | 26.8 | 23.8 |
| Цэвэр хөрөнгө өмчийн дүн | 7,508.5 | 9256.6 | 1748.1 |
| Засгийн газрын хувь оролцоо | 7,508.5 | 9256.6 | 1748.1 |
| **Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **7,511.5** | **9283.4** | **1771.9** |

*Эх сурвалж: Түргэн сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан*

### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 290.7 сая төгрөг болж 146.7 сая төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлого, Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

***Түргэн сумын Засаг даргын тамгын газар:***

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолтын зардлыг шууд зардалд бүртгэсэн 3.6 сая төгрөгийн алдаа байсанд залруулга хийсэн.*

***Түргэн сумын Соёлын төв***

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолт, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг шууд зардалд бүртгэсэн 0.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.*

***Түргэн сум дахь Сум дундын ойн анги***

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасныг зөрчин дотоод томилолтын зардлыг шууд зардалд бүртгэсэн 1.3 сая төгрөгийн алдаа зөрчлийг залрууллаа.*

### 3.5.2 Авлага

Авлага дансны үлдэгдэл 266.9 сая төгрөг болж 88.8 сая төгрөгөөр өссөн нь Сум хөгжүүлэх сан, Эрүүл мэндийн төвийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

***Түргэн сумын Засаг даргын тамгын газар:***

- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.3 дэх хэсэгт заасныг зөрчин 0.9 сая төгрөгийн хувь хүнээс авах авлагыг бүртгэлд тусгаагүй байсныг залруулга хийсэн.*

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 312.3 сая төгрөг болж 18.7 сая төгрөгөөр өссөн нь Ерөнхий боловсролын сургууль, Эрүүл мэндийн төвийн бараа материал нэмэгдсэнээс шалтгаалжээ.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 8,413.5 сая төгрөг болж 1.517.8 сая төгрөгөөр өссөн нь Соёлын төвийн шинэ барилга ашиглалтад орсонтой холбоотой байна.

### 3.5.5 Өр төлбөр

Өр төлбөрийн данс 26.8 сая төгрөг болж 23.8 сая төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотой Эрүүл мэндийн төв дээр үүссэн эм болон бусад хувцас хэрэглэлийн өр байна.

### 3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,256.6 сая төгрөг болж 1,748.1 сая төгрөгөөр буюу 23.3 хувиар өссөн байна

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,093.5 сая төгрөгөөр буюу 61.3 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 515.5 сая төгрөгөөр буюу 16.7 хувиар өссөн байна.

### 3.5.7 Орлогын данс

Тайлант онд татварын орлого 63.9 сая, татварын бус орлого 2,017.3 сая, тусламж санхүүжилтийн орлого 3,427.7 сая, нийт 5,508.9 сая төгрөгийн үйл ажиллагааны орлого орсон байна.

### 3.5.8 Зардлын данс

Зардлын данстай холбоотой Төсвийн шууд захирагчид 0.5 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Аудитын илрүүлэлт:

***Түргэн сумын Ерөнхий боловсролын сургууль:***

*- Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.4 дэх хэсэгт "Сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл сахилгын шийтгэлгүйд тооцно", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэгт "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй" гэж заасныг зөрчин сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчид 2, 4-р улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалд 0.3 сая төгрөг тооцож олгосон алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.*

***Түргэн сум дахь Сум дундын ойн анги:***

*- Түргэн сум дахь Сум дундын ойн анги нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг зөрчин 0.2 сая төгрөгийн цалинг илүү тооцож олгосон алдаа зөрчилд төлбөрийн акт тогтоолоо.*

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Түргэн сумын 2021 оны төсвийг сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 2/04 дүгээр тогтоолоор 2,233.0 сая төгрөгөөр баталж 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 4/05 дугаар тогтоолоор тодотгол хийж анх баталсан дүнгээс 2,261.5 сая төгрөгөөр өсгөж 28.5 сая төгрөгөөр өсгөж баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөр, 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,261.5 сая төгрөгийн төсөв баталснаас 1,304.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 855.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22.0 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 79.0 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,275.6 сая, орон нутгийн төсвөөс 806.1 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 21.4 сая, төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 103.9 сая, нийт 2,207.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,146.1 сая төгрөгийг зарцуулж улсын төсөвт 28.9 сая, орон нутгийн төсөвт 68.5 сая, нийт 97.5 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,146.1 сая төгрөг буюу 94.9 хувьтай байгаа нь зардлыг 97.5 сая төгрөгөөр хэмнэж, тусгай зориулалтын шилжүүлгээс 17.9 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Түргэн сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн сумын 2021 оны тодотгосон төсөв батлах тухай 04/05 дугаар тогтоолд зааснаар Түргэн сумын Засаг дарга тайлант онд 46.2 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 183.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 398.0 хувиар биелүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 16.2 сая, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 11.0 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 223.8 сая, нийт 250.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж 243.9 сая төгрөгийг зарцуулж, 7.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн нэгтгэсэн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

## 3.8 Аудитын гол асуудал

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Түргэн сумын Засаг даргын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 157 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа хоцроож 6 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй болно.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 126.6 сая төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

### 3.12 Харьяа байгууллагуудын аудитын дүнгийн талаар

Түргэн сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 7 төсвийн байгууллага, 3 тусгай сан, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 7 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 санг түүвэрт хамруулсан.

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитад хамрагдсан төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 7 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудад хийсэн аудитаар нийт 6.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 0.5 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 6.2 сая төгрөгийн 4 алдааг залруулаа.

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | ЗДТГ | 2 | 4.6 | 2 | 4.6 | | | | | | |
| 2 | ЕБС | 1 | 0.3 | | | 1 | 0.3 | | | | |
| 3 | Түргэн сумын Соёл | 1 | 0.3 | 1 | 0.3 | | | | | | |
| 4 | Сум дундын ойн анги | 2 | 1.5 | 1 | 1.3 | 1 | 0.2 | | | | |
| | **Дүн** | **6** | **6.7** | **4** | **6.2** | **2** | **0.5** | | | | |

**4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

/сая төгрөгөөр/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Түргэн сумын Засаг дарга | 0 | 0.0 | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |
| | **НИЙТ** | **0** | **0.0** | | | | | | | | |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Р.АЮУШ/

2022 оны 03 сарын 22-ны өдөр

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
20
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ